



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 08 сарын 28 өдөр

Дугаар а/159

Улаанбаатар хот


Өргөдлийн цахим дугаар олгох үйл
ажиллагааг хойшлуулах тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Тагнуулын ерөнхий газрын 2017 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 01/1096 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тагнуулын ерөнхий газрын 2017 оны 01/1096 тоот албан бичгээр "...хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн дугаар олгох цахим системийг хянах, шалгах шаардлагатай тул 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдах сонгон шалгаруулалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулах" тухай мэдэгдэл ирүүлсэн тул 2017 оны 8 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулах хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийн цахим дугаар олгох үйл ажиллагааг хойшлуулсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2017 оны а/156 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрдэс баялгийн салбарын асуудал хариуцсан орлогч дарга /Н.Энхжаргал/-д даалгасугай.

ДАРГА  Б.БААТАРЦОГТ